# МОНГОЛ УЛС
# ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 06 өдөр Дугаар А/563 Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолоор баталсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн А/520 дугаар захирамжийн дагуу 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр явагдах газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:
Б.Эрдэнэдалай (Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Ө.Дугарсүрэн (Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэдээллийн сан, техник, программ хангамж хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:
Б.Батмөрөн (Аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын газрын татвар, төлбөр, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Газар эзэмшүүлэх цахим дуудлага худалдааг хууль тогтоомжийн дагуу хариуцлагатай зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Эрдэнэдалай)-д даалгасугай.

3. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлагатай ажиллахыг анхааруулсугай.

4. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6712011277